



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 67

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1, "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээ"-ний тухай Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл-Тариалан сумын 35 кВ-ын 86.7 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын барилга угсралтын ажлын хүрээнд бий болсон 30 нэрийн нийт 568,114,364.00 (таван зуун жаран найман сая нэг зуун арван дөрвөн мянга гурван зуун жаран дөрвөн) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Батгэрэл, "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Нямсамбуу нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.НАРАНГЭРЭЛ

0000118

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 03 дугаар сарын 08-ны өдрийн
67 дугаар тогтоолын хавсралт

**"ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ШИНЭЭР БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хүчин чадал		Нэгжийн үнэ /төгрөг/	Балансын үнэ /төгрөг/
			хэмжих нэгж	биет хэмжээ		
1	110 кВ-ын хүчний трансформатор SFSZ-4000/110	2013	ш	1	246,239,664.00	246,239,664.00
2	35 кВ-ын элегаз таслуур	2013	ш	2	34,626,500.00	69,253,000.00
3	35 кВ-ын 2 газардуулгын хутгатай салгуур	2013	ком	2	3,826,500.00	7,653,000.00
4	35 кВ-ын 1 газардуулгын хутгатай салгуур	2013	ком	3	3,326,500.00	9,979,500.00
5	35 кВ-ын цэнэг шавхагч	2013	ком	1	2,900,000.00	2,900,000.00
6	Тогтмол гүйдлийн панель	2013	ком	2	46,600,000.00	93,200,000.00
7	Аккумулятор	2013	ш	18	600,000.00	10,800,000.00
8	PXA панель	2013	ком	1	3,500,000.00	3,500,000.00
9	35кВ-ын гүйдлийн трансформатор	2013	ш	6	2,500,000.00	15,000,000.00
10	35кВ-ын хүчдэлийн трансформатор	2013	ш	3	2,300,000.00	6,900,000.00
11	Электрон тоолуур	2013	ш	2	2,200,000.00	4,400,000.00
12	Реле SEL-387E	2013	ш	1	24,776,700.00	24,776,700.00
13	Реле SEL-351A	2013	ш	3	6,006,000.00	18,018,000.00
14	Реле SEL-751A	2013	ш	1	6,942,000.00	6,942,000.00
15	Төв дохиоллын төхөөрөмж	2013	ш	1	7,875,000.00	7,875,000.00
16	Гэрэлтүүлэгч	2013	ш	3	100,000.00	300,000.00
17	Тулгуур изолятор	2013	ш	6	45,000.00	270,000.00
18	Изолятор	2013	ш	72	30,000.00	2,160,000.00
19	Шин AC-70/11	2013	м	300	25,000.00	7,500,000.00
20	Кабель КВВГ 7*1,5	2013	м	180	8,500.00	1,530,000.00
21	Кабель КВВГ 10*1,5	2013	м	120	10,200.00	1,224,000.00

22	Кабель КВВГ 14*1,5	2013	м	115	10,900.00	1,253,500.00
23	Кабель АКВВГ 14*2,5	2013	м	80	5,500.00	440,000.00
24	УСО-2А тулгуур	2013	ш	10	180,000.00	1,800,000.00
25	УСО-5А таслуур	2013	ш	4	75,000.00	300,000.00
26	Портал ВС-105	2013	ш	8	1,200,000.00	9,600,000.00
27	Аянга зайлуулагч СВ-95	2013	ш	1	780,000.00	780,000.00
28	Лотки	2013	ш	20	180,000.00	3,600,000.00
29	Лоткины таг	2013	ш	40	98,000.00	3,920,000.00
30	Хашаа	2013	ш	40	150,000.00	6,000,000.00
Нийт дүн						568,114,364.00
(таван зуун жаран найман сая нэг зуун арван дөрвөн мянга гурван зуун жаран дөрвөн)						